

ОРЛОГЫН ТАТВАРЫГ ДАВХАРДУУЛЖ НОГДУУЛАХГҮЙ БАЙХ, ТАТВАР  
ТӨЛӨХӨӨС ЗАЙЛСХИЙХ ЯВДЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ  
МОНГОЛ УЛС, НИДЕРЛАНДЫН ВАНТ УЛС ХООРОНДЫН КОНВЕНЦ

Монгол Улсын Засгийн газар

ба

Нидерландын Вант Улсын Засгийн газар,

Орлогын татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс  
зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Конвенцийг байгуулахыг  
эрмэлзэн,

Дараах зүйлийг хэлэлцэн тохиров:

**1 дүгээр бүлэг**

**КОНВЕНЦИЙН ХАМААРАХ ХҮРЭЭ**

1 дүгээр зүйл

**ХАМААРАГДАХ ЭТГЭЭД**

Энэхүү Конвенц нь Хэлэлцэн тохирогч хоёр Улс буюу тэдгээрийн аль нэгний  
нутаг дэвсгэрт байнга оршин суугч этгээдэд хамаарна.

2 дугаар зүйл

**ХАМААРАГДАХ ТАТВАРУУД**

1. Хэлэлцэн тохирогч Улс, түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн  
нэгжээс орлогод ногдуулж буй татварууд нь тэдгээрийг хэрхэн  
ногдуулж байгаа хэлбэрээс үл шалтгаалан энэхүү Конвенцид  
хамаарна.
2. Орлогод ногдуулж буй татвар гэж нийт орлого болон орлогын  
бүрэлдэхүүн хэсэгт ногдуулж буй бүх төрлийн татвар түүний дотор  
хөдлөх ба үл хөдлөх хөрөнгийн борлуулалтын орлого, аж ахуйн  
нэгжээс олгож буй цалин хөлсний нийт хэмжээ болон хөрөнгийн  
үнэлгээний өсөлтийн орлогод ногдуулах татварыг хэлнэ.
3. Энэхүү Конвенцид дараах татварууд хамаарагдана:

а) Монголын хувьд:

- хүн амын орлогын албан татвар,
- аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар

(цаашид "Монголын татвар" гэх).

б) Нидерландын хувьд:

- де инкомстенбеластинг (орлогын татвар),
- де луунбеластинг (цалингийн татвар),
- а венууцчапсбеластинг (компаний татвар) түүний дотор 1967 онд гаргасан хөнгөлөлтийн дагуу Мижнвуэт 1810 (1810 оны ашигт малтмалын хууль) буюу Мижнвуэт тивийн эргийн орчмын нутаг 1965 (1965 оны Нидерландын тивийн эргийн орчмын нутгийн ашигт малтмалын хууль)-аар байгалийн баялгийг олборлож олсон цэвэр ашигт Засгийн газрын эзлэх хувь,
- де дивидендбеластинг (ногдол ашгийн татвар)

(цаашид "Нидерландын татвар" гэх);

4. Энэхүү Конвенцид гарын үсэг зурсан өдрөөс хойш Хэлэлцэн тохирогч аль нэг Улсад хэрэглэж буй татварууд дээр нэмэлт байдлаар ногдуулсан, эсвэл оронд нь шинээр бий болсон татварууд нь хэрэглэж буй татваруудтай адил буюу төстэй байвал энэхүү Конвенцид мөн хамаарна. Хэлэлцэн тохирогч Улсуудын эрх бүхий байгууллагууд нь өөрийн орны татварын хуулиудад орсон аливаа чухал өөрчлөлтийн талаар бие биедээ харилцан мэдэгдэж байна.

## 2 дугаар бүлэг

### ТОДОРХОЙЛОЛТ

#### 3 дугаар зүйл

### ЕРӨНХИЙ ТОДОРХОЙЛОЛТ

1. Энэхүү Конвенцид өөрөөр заагаагүй бол:

а) "Хэлэлцэн тохирогч Улс" гэж тухайн заалтын утгаас хамааран Монгол Улс, эсвэл Нидерландын Вант Улс (Нидерланд)-ыг хэлнэ; "Хэлэлцэн тохирогч Улсууд" гэж Монгол Улс ба Нидерландын Вант Улс (Нидерланд)-ыг хэлнэ;

б) "Монгол Улс" гэж, газар зүйн утгаар авч үзвэл Монгол Улсын нутаг дэвсгэр, Монгол Улсын татварын хууль үйлчлэх нутаг дэвсгэр, түүнчлэн олон улсын эрх зүйн дагуу байгалийн нөөцийг

в) "Нидерланд Улс" гэж Европт оршдог Нидерландын Вант Улсын хэсэг, түүний дотор хилийн ус болон хилийн усны гаднах нутаг дэвсгэрийг оролцуулан Нидерланд Улс нь олон улсын эрх зүй, хууль ёсны эрх болон бүрэн эрхээ хэрэгжүүлэх далайн ёроол, түүний газрын хэвлий ба түүний дээрх ус, мөн тэдгээрийн байгалийн баялгийг хэлнэ;

г) "этгээд" гэж хувь хүн, компани болон аливаа бусад этгээдийг хэлнэ;

д) "компани" гэж татварын утгаараа аж ахуйн нэгж хэмээн тооцогдох аливаа аж ахуйн нэгж эсвэл бусад нэгжийг хэлнэ;

е) "Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгж" ба "Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын аж ахуйн нэгж" гэж тухайн энэ Улсад байнга оршин суугч этгээдийн эрхэлдэг аж ахуйн нэгжийг, Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суугч этгээдийн эрхэлдэг аж ахуйн нэгжийг тус тус хэлнэ;

ж) "олон улсын тээвэр" гэж Хэлэлцэн тохирогч Улсад гол удирдлага нь байрладаг аж ахуйн нэгжийн явуулж буй хөлөг онгоц болон нисэх онгоц, хуурай болон төмөр замын тээврийн хэрэгслээр хийх аливаа тээврийн үйл ажиллагааг хэлнэ. Харин Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дахь цэгүүдийн хооронд хөлөг онгоц болон нисэх онгоц, хуурай болон төмөр замын тээврийн хэрэгслээр хийх тээврийн үйл ажиллагаа үүнд үл хамаарна;

з) "харъяат" гэж Хэлэлцэн тохирогч Улсын харъяат аливаа хувь этгээд болон Хэлэлцэн тохирогч Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн дагуу өөрийн статусыг эдэлж байгаа хуулийн этгээд, нөхөрлөл ба нэгтгэл;

и) "эрх бүхий байгууллага" гэж,

i) Монгол Улсын хувьд Санхүү, эдийн засгийн сайд буюу түүний эрх бүхий төлөөлөгчийг хэлнэ.

ii) Нидерланд Улсын хувьд Сангийн сайд буюу түүний эрх бүхий төлөөлөгчийг хэлнэ.

2. Хэлэлцэн тохирогч аль нэг Улс энэхүү Конвенцийг хэрэглэх явцад Конвенцид тодорхойлогдоогүй аливаа нэр томъёог Конвенцид өөрөөр заагаагүй бол Конвенцид хамаарч буй татвартай холбогдол бүхий Хэлэлцэн тохирогч Улсын хуульд зааснаар ойлгоно. Хэлэлцэн тохирогч Улсын татварын хуульд заасан аливаа нэр томъёо, ойлголтыг уг Улсын бусад хуульд заасан нэр томъёо, ойлголтоос давуутай авч үзнэ.

## БАЙНГА ОРШИН СУУГЧ

1. Энэхүү Конвенцид "Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суугч" гэж байнга оршин сууж, байрлаж, удирдлагын байгаа газар буюу үүнтэй адилтгах бусад шалтгаанаар тухайн улсын хууль тогтоомжийн дагуу татвар төлөх үүрэг бүхий аливаа этгээдийг хэлнэ. Гэхдээ зөвхөн тухайн Улс дахь эх үүсвэрээс олсон орлогоос тухайн Улсад татвар төлөх үүрэгтэй аливаа этгээдэд энэхүү нэр томъёо хамаарахгүй.
2. Мөн "Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суугч" гэж тухайн Улс, түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болон Хэлэлцэн тохирогч Улсын хууль тогтоомжийн дагуу хүлээн зөвшөөрөгдөн, хянагддаг тэтгэврийн санг хэлнэ.
3. Энэхүү зүйлийн 1 дүгээр заалтын дагуу Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алинд нь байнга оршин суугч хувь этгээдийн статусыг дараах байдлаар тодорхойлно:
  - а) байнга амьдардаг орон гэр нь Хэлэлцэн тохирогч аль Улсад байгаагаар нь тэр Улсад байнга оршин суугч гэж тооцно. Хэрэв хувь этгээд нь Хэлэлцэн тохирогч хоёр улсын аль алинд нь байнга амьдардаг орон гэртэй бол Хэлэлцэн тохирогч аль Улсад түүний хувийн ба эдийн засгийн харилцаа (язгуур эрх ашгийн төв) нь илүү ойр дөт байгаагаар нь тэндхийн байнга оршин суугч гэж тооцно.
  - б) Хэрэв түүний язгуур эрх ашгийн төв бүхий Улсыг тодорхойлох боломжгүй эсвэл, энэ хувь этгээд нь Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алинд нь байнга амьдардаг орон гэргүй бол Хэлэлцэн тохирогч аль Улсад түр орогнох байртай байгаагаар нь тэр Улсад байнга оршин суугч гэж тооцно.
  - в) Хэрэв хувь этгээд нь Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алинд нь орогнох байртай, эсвэл алинд нь ч байхгүй бол түүнийг Хэлэлцэн тохирогч аль Улсын харъяат байгаагаар нь тэр Улсад байнга оршин суугч гэж тооцно.
  - г) Хэрэв хувь этгээдийг Хэлэлцэн тохирогч аль улсын харъяат гэдгийг дээрх шалгуураар тогтоох боломжгүй бол асуудлыг Хэлэлцэн тохирогч Улсуудын эрх бүхий байгууллагууд хэлэлцэж шийдвэрлэнэ.
4. Энэхүү зүйлийн 1 дүгээр заалтын дагуу хувь этгээдээс бусад хуулийн этгээд Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алинд нь байнга оршдог бол түүний голлох удирдлага нь Хэлэлцэн тохирогч аль Улсад байрлаж байгаагаар нь тэр Улсын байнга оршин суугч гэж тооцно.

5 дугаар зүйл

ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР

1. Энэхүү Конвенцид "Төлөөлөгчийн газар" гэж аж ахуйн нэгж өөрийн үйл ажиллагаагаа бүхэлд нь буюу хэсэгчлэн явуулдаг бизнесийн байнгын байрлалыг хэлнэ.
2. "Төлөөлөгчийн газар" гэдэгт тухайлбал;
  - а) аж ахуйг удирдан явуулж буй газар,
  - б) салбар байгууллага,
  - в) албан контор,
  - г) үйлдвэр
  - д) цех болон
  - е) уурхай, газрын тос буюу байгалийн хийн цооног, ил уурхай буюу байгалийн ашигт малтмал олборлож буй аливаа бусад газар орно.
3. Барилгын талбай, барилга байгууламж буюу угсралт суурилуулалтын төсөл зэрэг нь зөвхөн 12 сараас дээш хугацаагаар үргэлжилэх тохиолдолд төлөөлөгчийн газар гэж үзнэ.
4. Энэ зүйлийн өмнөх заалтуудыг үл харгалзан "Төлөөлөгчийн газар" гэдэгт дараах үйл ажиллагааг үл хамааруулна:
  - а) аж ахуйн нэгж өөрийн бараа буюу эд агуурсыг зөвхөн хадгалах, үзүүлэх буюу нийлүүлэх зорилгоор аливаа байгууламжийг ашиглах;
  - б) аж ахуйн нэгж өөрийн бараа буюу эд агуурсын нөөцийг зөвхөн хадгалах, үзүүлэх буюу нийлүүлэх зорилгоор байлгах;
  - в) аж ахуйн нэгж өөрийн бараа буюу эд агуурсын нөөцийг өөр аж ахуйн нэгжээр зөвхөн боловсруулалт хийлгэх зорилгоор байлгах;
  - г) аж ахуйн нэгж нь өөртөө зориулан бараа буюу эд агуурс зөвхөн худалдан авах эсвэл мэдээлэл цуглуулах зориулалтаар байнгын байрлал байлгах;
  - д) аж ахуйн нэгж нь өөртөө зориулан зөвхөн бэлтгэх, туслах шинж чанартай аливаа үйл ажиллагаа явуулах зорилгоор байнгын байрлал байлгах;
  - е) байнгын байрлалын бүх үйл ажиллагаа нь бэлтгэх, туслах шинж чанарын хоршсон үйл ажиллагаанаас бүрдсэн тохиолдолд зөвхөн

а)-аас д) хүртэлх дэд заалтуудад дурдсан төрлийн үйл ажиллагааг аливаа байдлаар нэгтгэн бизнес эрхлэх байнгын байрлал байлгах.

5. Энэхүү зүйлийн 1 ба 2 дугаар заалтуудыг үл харгалзан 6 дугаар заалтад хамаарах бие даасан эрх бүхий төлөөлөгчөөс бусад этгээд Хэлэлцэн тохирогч Улсад аж ахуйн нэгжийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж гэрээ /контракт/ байгуулах эрх эдэлдэг бол тухайн аж ахуйн нэгжийг өөрийн тусын тулд явуулж буй аливаа үйл ажиллагааны хувьд нь тухайн Улсад төлөөлөгчийн газартай гэж тооцно. Гэхдээ уг этгээдийн үйл ажиллагаа нь 4 дүгээр заалтад дурдсан үйл ажиллагаагаар хязгаарлагдан, хэрэв энэхүү үйл ажиллагаа байнгын байрлалаар дамжин явагдаж байвал уг байнгын байрлалыг энэхүү заалтын дагуу төлөөлөгчийн газартай гэж үзэхгүй.
6. Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгж нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад брокер, ерөнхий комиссын төлөөлөгч, бие даасан эрх бүхий бусад төлөөлөгчдөөр дамжуулан үйл ажиллагаа явуулж байгаа нь түүнийг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад төлөөлөгчийн газартай гэж үзэх үндэс болохгүй бөгөөд тэдгээр этгээд нь өөрийн тогтсон чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг байх нь үүний нөхцөл болно. Гэхдээ ийм төлөөлөгчийн үйл ажиллагаа нь бүхэлдээ буюу дийлэнхдээ тухайн аж ахуйн нэгжийн нэрийн өмнөөс хийгдэж байгаа бол түүнийг бие даасан эрх бүхий төлөөлөгч гэж энэхүү заалтын хүрээнд хамааруулахгүй.
7. Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршдог компани нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршдог, эсвэл Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад үйл ажиллагаагаа (төлөөлөгчийн газраар дамжуулах буюу бусад аргаар) явуулдаг компанийг хянадаг эсвэл хяналтанд байдаг нь эдгээр компанийг бие биеийнх нь төлөөлөгчийн газар гэж үзэх үндэс болохгүй.

### 3 дугаар бүлэг

## ОРЛОГЫН ТАТВАР

### 6 дугаар зүйл

## ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨӨС ОРОХ ОРЛОГО

1. Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суугчийн Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байрладаг үл хөдлөх хөрөнгөөс олсон орлогод (түүний дотор хөдөө аж ахуй болон ойн аж ахуйгаас олсон орлого) Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар ногдуулж болно.
2. "Үл хөдлөх хөрөнгө" гэдгийг тухайн хөрөнгө байрлаж буй Хэлэлцэн тохирогч Улсын хуульд зааснаар ойлгоно. Аль ч тохиолдолд, уг нэр томъёонд үл хөдлөх хөрөнгөд дагалдах өмч, хөдөө аж ахуй болон ойн аж ахуйд ашиглагдаж буй мал амьтан, тоног төхөөрөмж, газар оролцсон өмчийн талаарх хуулийн заалт хэрэглэх эрх, бусдын үл хөдлөх хөрөнгийг хязгаартайгаар эзэмшин ашиглах эрх, ашигт

4. Энэхүү зүйлийн 1 болон 3 дугаар заалт нь аж ахуйн нэгжийн үл хөдлөх хөрөнгө, түүнчлэн бие даасан хувийн үйлчилгээ үзүүлэхэд ашигласан үл хөдлөх хөрөнгөөс олсон орлогод хамаарна.

### 7 дугаар зүйл.

## АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ

1. Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгж нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын нутагт байрладаг төлөөлөгчийн газраар дамжуулан аж ахуйн үйл ажиллагаа эрхлээгүй тохиолдолд уг аж ахуйн нэгжийн ашигт зөвхөн Хэлэлцэн тохирогч Улс татвар ногдуулна. Хэрэв аж ахуйн нэгж нь дээр дурдсан байдлаар үйл ажиллагаа эрхэлж байвал уг аж ахуйн нэгжийн ашгийн зөвхөн тухайн байнгын төлөөлөгчийн газарт хамаарах хэсэгт Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар ногдуулж болно.
2. Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгж, Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын нутагт байрладаг өөрийн төлөөлөгчийн газраар дамжуулан аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй тохиолдолд уг төлөөлөгчийн газар нь төлөөлж буй аж ахуйн нэгжтэйгээ бүрэн бие даасан байдлаар харьцан адил, эсвэл төстэй үйл ажиллагаа, адил буюу төстэй нөхцөлд эрхлэн явуулж олж болох байсан ашгийг энэхүү зүйлийн 3 дугаар заалтын дагуу уг төлөөлөгчийн газрын ашиг гэж Хэлэлцэн тохирогч Улс бүрт тооцно.
3. Төлөөлөгчийн газрын ашгийг тодорхойлохдоо тус төлөөлөгчийн газрын аж ахуйн үйл ажиллагааг эрхлэн явуулахад өөрийн оршин байгаа Хэлэлцэн тохирогч Улс болон бусад Улсад зарцуулсан аж ахуйн зардлыг түүний дотор ерөнхий ба удирдлагын захиргааны зардлыг хасч тооцно.
4. Хэлэлцэн тохирогч Улсад аливаа аж ахуйн нэгж өөрийн салбарууддаа нийт ашгийг хуваарилдаг аргаар төлөөлөгчийн газрын орлогыг тодорхойлж хэвшсэн бол Хэлэлцэн тохирогч Улс энэ хэвшсэн аргаар татвар ногдох орлогыг тодорхойлоход энэхүү зүйлийн 2 дугаар заалт ямар ч тохиолдолд саад болохгүй. Гэхдээ хэвшсэн аргаар орлогыг хуваарилсантай холбогдон гарах үр дүн нь энэ зүйлийн зарчмуудтай зөрчилдөхгүй байвал зохино.

7. Хэрэв ашиг нь энэхүү конвенцийн бусад зүйлд хамааралтай орлогын төрлийг өөртөө агуулсан бол тэдгээр зүйлийн заалтыг мөрдөхөд энэхүү зүйлийн заалтууд үл нөлөөлнө.

### 8 дугаар зүйл

#### ОЛОН УЛСЫН ТЭЭВЭР

1. Олон улсын шугамд хөлөг онгоц, нисэх онгоц, хуурай болон төмөр замын тээврийн хэрэгслээр тээвэр хийж олсон ашигт зөвхөн тухайн аж ахуйн нэгжийн голлох удирдлага байрладаг Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулна.
2. Хэрэв хөлөг онгоцны аж ахуйн нэгжийн голлох удирдлага нь хөлөг онгоцон дээрээ байрладаг бол уг хөлөг онгоцны харъяалах боомт оршдог Хэлэлцэн тохирогч Улсад байрладаг гэж үзнэ, хэрэв харъяалах боомт үгүй бол уг хөлөг онгоцны эзэмшигч байнга оршин сууж байгаа Хэлэлцэн тохирогч Улсад гэж үзнэ.
3. 1 дүгээр заалт нь аж ахуйн пул (pool), хамтарсан үйлдвэр болон олон улсын тээврийн ашиглалтын байгууллагын үйл ажиллагаанд оролцож олсон ашигт мөн хамаарна.

### 9 дүгээр зүйл

#### ХАРЪЯА АЖ АХУЙН НЭГЖҮҮД

##### 1. Хэрэв

а) хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгж Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын аж ахуйн нэгжийн удирдлага, хяналт болон хөрөнгөд шууд буюу шууд бусаар оролцдог, эсвэл

б) тухайн этгээдүүд Хэлэлцэн тохирогч Улсын болон Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын аж ахуйн нэгжийн аль алиных нь удирдлага, хяналт болон хөрөнгөд шууд буюу шууд бусаар оролцдог бол,

Тэдгээр хоёр нэгжийн хооронд тогтсон худалдаа, санхүүгийн харилцааны нөхцөл нь бие даасан аж ахуйн нэгжүүдийн хоорондын харилцааны нөхцлөөс ялгаатай бөгөөд тухайн аль нэг аж ахуйн нэгжид ногдох ёстой аливаа ашиг дээрх ялгаатай нөхцлийн улмаас тооцогдоогүй байвал түүнийг уг аж ахуйн нэгжийн ашигт оруулан



- тооцож зохих журмын дагуу татвар ногдуулж болно. Гэхдээ харъяа аж ахуйн нэгжүүд нь гүйцэтгэх, ерөнхий захиргааны, техникийн болон арилжааны зардлууд, судалгаа ба хөгжлийн зардлууд болон бусад адил төстэй зардлуудын хуваарилалтын үндсэн дээр зардал хуваалцах зохицуулалт буюу ерөнхий үйлчилгээний гэрээ хийх замаар хоорондоо зохицуулалт хийхээр тохирсон нь өмнөх өгүүлбэрт заасан нөхцөл болохгүй гэж ойлгоно.
2. Хоёр аж ахуйн нэгжийн хоорондын харилцаа нь бие даасан аж ахуйн нэгжийн хоорондын харилцааны нөхцөлтэй нийцэж байх тохиолдолд Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын аж ахуйн нэгжээс өөрийн Улсдаа татвар авах ёстой ашгийг эхэнд дурдсан Улс өөрийн ашиг гэж тооцон өөрийн аж ахуйн нэгжийн ашигт оруулан татвар ногдуулсан байвал нөгөө Улс энэхүү ашгаас авах татварын хэмжээнд холбогдох зохицуулалт хийж болно. Ийм зохицуулалтыг хийхдээ энэхүү Конвенцийн бусад заалтуудыг харгалзан үзэх бөгөөд Хэлэлцэн тохирогч Улсуудын эрх бүхий байгууллагууд шаардлагатай гэж үзвэл харилцан зөвлөлдөж болно.

#### 10 дугаар зүйл

#### НОГДОЛ АШИГ

1. Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршдог компаниас Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суугчид төлсөн ногдол ашигт нөгөө Улс татвар ногдуулж болно.
2. Гэхдээ ногдол ашиг төлж буй компани байнга оршдог Хэлэлцэн тохирогч Улс тухайн ногдол ашигт өөрийн хууль тогтоомжийн дагуу татвар ногдуулж болох боловч, хэрэв уг ногдол ашгийн жинхэнэ эзэмшигч нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын байнга оршин суугч бол ногдуулах татварын хэмжээ нь ногдол ашгийн нийт дүнгийн 15 хувиас хэтрэхгүй.
3. Энэхүү зүйлийн 2 дугаар заалтыг үл харгалзан хэрэв ногдол ашиг эзэмшигч нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын байнгын оршин суугч бөгөөд компанийн хөрөнгө нь бүрэн буюу хэсэгчилсэн хувьцаанд хуваагддаг ба ногдол ашиг төлж буй компанийн хөрөнгийн 10-аас доошгүй хувийг шууд эзэмшиж байвал тухайн компанийн төлж буй ногдол ашигт уг компани байнга оршдог Хэлэлцэн тохирогч Улс нь татвар ногдуулахгүй.
4. 2 ба 3 дугаар заалтууд нь ногдол ашиг агуулагдсан орлогод ногдуулах татварт үл хамаарна.
5. Энэхүү зүйлд тусгагдсан "ногдол ашиг" гэж хувьцааны ногдол ашиг, уул уурхайн ногдол ашиг, үүсгэн байгуулагчийн ногдол ашиг буюу бусад эрх, өрийн нэхэмжлэлээс бусад хэлбэрээр ашигт оролцох эрх болон бусад эрхээс үүсэх орлого мөн түүнчлэн ногдол ашгийн хуваарилалт хийжбуй компанийн байнга оршдог Хэлэлцэн тохирогч Улсын хуулийн

дагуу хувьцааны ногдол ашгийн нэгэн адилаар татварт хамруулдаг аж ахуйн эрхээс олох орлогыг хэлнэ.

6. Хэрэв ногдол ашгийн эрхийг жинхэнэ эзэмшигч нь Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршдог бөгөөд ногдол ашиг төлөгч компани Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байрладаг төлөөлөгчийн газар буюу бие даасан хувийн үйлчилгээ эрхэлдэг товлосон газраар дамжуулан аж ахуйн үйл ажиллагаа явуулдаг ба ногдол ашиг хүртэж байгаа нь хэрэг дээрээ энэ төлөөлөгчийн газар буюу товлосон газартай шууд хамааралтай бол 1, 2 ба 3 дугаар заалтыг баримтлахгүй. Энэ тохиолдолд 7 буюу 14 дүгээр зүйлийн аль тохиромжтойг хэрэглэнэ.
7. Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршдог компани Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад ашиг буюу орлого олж байвал нөгөө Улс уг компаниас төлж буй ногдол ашигт татвар ногдуулахгүй байж болно. Гэхдээ энэ тохиолдолд тухайн ногдол ашгийг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суугчид төлсөн эсвэл ногдол ашиг хүртэж байгаа нь хэрэг дээрээ Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад төлөөлөгчийн газар буюу байнгын байрлал байгаатай шууд хамааралтай бол татвар ногдуулж болно. Мөн компанийн хуваарилагдаагүй ашигт төлөгдсөн ногдол ашиг буюу хуваарилагдаагүй ашиг нь бүхэлдээ буюу хэсэгчлэн нөгөө Улсад бий болсон ашиг орлогоос бүрдэж байлаа ч гэсэн татвар ногдуулахгүй байж болно.

### 11 дүгээр зүйл

#### ХҮҮ

1. Хэлэлцэн тохирогч Улсад бий болж, Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суугч этгээдэд төлсөн хүүд нөгөө Улсад татвар ногдуулж болно.
2. Гэхдээ хүү бий болсон Хэлэлцэн тохирогч Улс өөрийн хуулийн дагуу уг хүүд татвар ногдуулж болох боловч хэрэв хүүгийн жинхэнэ эзэмшигч нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суудаг бол ногдуулах татварын хэмжээ хүүгийн нийт дүнгийн 10 хувиас хэтэрч болохгүй.
3. 2 дугаар заалтыг үл харгалзан хэрэв дараах шаардлагуудын аль нэгийг нь хангасан тохиолдолд Хэлэлцэн тохирогч аль нэг Улсад бий болж, Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын байнга оршин суугч жинхэнэ эзэмшигчид төлсөн хүүгийн орлогод Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар ногдуулна:
  - а) хэлэлцэн тохирогч Улсын Засгийн газар өөрөө, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж ба Төв банк нь хүү төлөгч буюу хүлээн авагч байвал;
  - б) хэлэлцэн тохирогч Улсын Засгийн газар, Төв банк ба Хэлэлцэн тохирогч Улсын Засгийн газрын эзэмшилд буюу хяналтанд байгаа аливаа агентлаг (санхүүгийн байгууллагыг

в) банк ба аливаа бусад санхүүгийн байгууллага (даатгалын компанийг оруулан)-аас олгосон зээллэгтэй холбоотойгоор төлсөн хүү;

г) үйлдвэрлэл, худалдаа буюу эрдэм шинжилгээний аливаа тоног төхөөрөмжийг зээлээр худалдсантай холбоотойгоор төлсөн хүү.

4. Энэхүү зүйлд тусгагдаж буй "хүү" гэсэн нэр томъёонд барьцаагаар баталгаажуулсан эсэх, зээлдэгчийн орлогод оролцох эрхтэй эсэхийг үл харгалзан бүх төрлийн өрийн нэхэмжлэлээс үүссэн орлого, ялангуяа улсын зээллэгийн орлого, бусад үнэт цааснаас орох орлого, мөн тэдгээрийн урамшууллын орлого орно. Харин төлбөр тооцоо хожимдуулсны торгууль нь энэхүү зүйлд дурдсан хүү гэж тооцогдохгүй.
5. Хэрэв хүү авах эрхийг жинхэнэ эзэмшигч нь Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршдог боловч Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад төлөөлөгчийн газраараа дамжуулан үйл ажиллагаа явуулж, тэнд нь энэ хүү бий болж байгаа, эсвэл нөгөө Улсад оршдог товлосон газраас хувийн бие даасан үйлчилгээ эрхэлдэг бөгөөд хүү авах эрх нь дурдсан төлөөлөгчийн газар буюу товлосон газартай шууд хамааралтай бол энэхүү зүйлийн 1 ба 2 дугаар заалтыг мөрдлөгө болгохгүй. Энэ тохиолдолд 7 буюу 14 дүгээр зүйлийн аль тохиромжтойг хэрэглэнэ.
6. Хүү төлөгч нь Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугч бол хүүг уг Улсад бий болсон гэж үзнэ. Нөгөө талаар Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугч эсэхийг үл харгалзан хүүг төлөгч этгээд Хэлэлцэн тохирогч Улсад төлөөлөгчийн газар, эсвэл товлосон газартай бөгөөд үүнтэй холбогдон хүү төлөгдөж, уг хүү энэ төлөөлөгчийн газарт эсвэл товлосон газар бий болж байгаа бол дээрх төлөөлөгчийн газар, эсвэл товлосон газар оршиж байгаа Улсад хүү бий болсон гэж үзнэ.
7. Хэрэв хүү төлөгч болон хүү авах эрхийг жинхэнэ эзэмшигчийн хооронд мөн түүнчлэн тэдгээрийн болон ямар нэгэн хөндлөнгийн этгээдийн хоорондын онцлог харилцаанаас шалтгаалан төлж буй хүүгийн хэмжээ нь ийм харилцаа байхгүй байсан үед хүү төлөгч болон жинхэнэ эзэмшигч хоёр хоорондоо тохиролцож болох байсан хэмжээнээс хэтэрч байвал энэ зүйлийн заалтууд зөвхөн тохиролцож болох байсан хэмжээнд хамаарна. Энэ тохиолдолд хүүгийн төлбөрийн илүү гарсан зөрүүд Хэлэлцэн тохирогч Улс бүр өөрийн хуулийн дагуу энэхүү Конвенцийн бусад заалтыг харгалзан татвар ногдуулж болно.

#### 12 дугаар зүйл

#### ЭРХИЙН ШИМТГЭЛ

1. Хэлэлцэн тохирогч Улсад бий болж, Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суугчид төлж буй эрхийн шимтгэлд нөгөө Улсад татвар ногдуулж болно.

Тухайн улсын хуулийн дагуу татвар ногдуулж болох боловч уг эрхийн шимтгэлийн жинхэнэ эзэмшигч нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын байнга оршин суугч бол ийнхүү ногдуулж буй татвар нь эрхийн шимтгэлийн нийт дүнгийн 5 хувиас хэтэрч болохгүй.

3. Энэхүү зүйлд хэрэглэгдэж буй "эрхийн шимтгэл" гэсэн нэр томъёонд уран зохиолын хэвлэн нийтлэх эрх, урлаг, уран сайхан болон шинжлэх ухааны бүтээл, түүний дотор уран сайхны кино, патент, барааны тэмдэг болон дизайн, модель, зураг төсөл болон нууц томъёолол буюу процессийг ашигласан буюу ашиглах эрх эдэлсэн, буюу үйлдвэр, худалдаа буюу шинжлэх ухааны туршлагатай холбогдсон мэдээллийг ашигласан буюу ашиглах эрх эдэлсний төлөө төлж буй бүх төрлийн төлбөр хамаарна.
4. Хэрэв эрхийн шимтгэлийг жинхэнэ эзэмшигч нь Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршдог боловч Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дахь төлөөлөгчийн газраар дамжуулан үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд тэнд энэхүү орлого бий болж байгаа, эсвэл Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад оршдог товлосон газраар дамжуулан бие даасан хувийн үйлчилгээ хийдэг түүнчлэн эрхийн шимтгэлийн төлбөр авах эрх буюу хөрөнгө нь хэрэг дээрээ энэхүү төлөөлөгчийн газар, эсвэл товлсон газарт шууд хамааралтай бол энэхүү зүйлийн 1 ба 2 дугаар заалтыг баримтлахгүй. Энэ тохиолдолд 7 буюу 14 дүгээр зүйлийн аль тохиромжтойг хэрэглэнэ.
5. Эрхийн шимтгэл төлөгч нь Хэлэлцэн тохирогч Улс өөрөө, түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж буюу уг Улсын байнга оршин суугч бол уг эрхийн шимтгэлийг Хэлэлцэн тохирогч Улсад бий болсон гэж үзнэ. Нөгөө талаар Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суудаг эсэхийг үл харгалзан эрхийн шимтгэлийн төлбөр төлөгч этгээд уг Хэлэлцэн тохирогч Улсад төлөөлөгчийн газар эсвэл товлосон газраар дамжуулан эрхийн шимтгэлийн төлбөр төлөх үүрэг хүлээдэг бол тэрхүү төлөөлөгчийн газар эсвэл товлосон газрын оршиж байгаа Улсад эрхийн шимтгэлийг бий болсон гэж үзнэ.
6. Эрхийн шимтгэлийн төлбөр төлөх болон авах эрхийг жинхэнэ эзэмшигчид буюу тэдгээрийн болон бусад хөндлөнгийн этгээдийн хоорондын онцлог харилцаанаас шалтгаалан төлөгдсөн эрхийн шимтгэлийн хэмжээ нь ийм харилцаа байхгүй тохиолдолд түүнийг төлөгч ба жинхэнэ эзэмшигч хоёрын хоорондоо тохиролцож болох байсан хэмжээнээс хэтэрвэл энэхүү зүйлийн заалтууд зөвхөн тохиролцож болох байсан хэмжээнд хамаарна. Энэ тохиолдолд төлбөрийн илүү гарсан зөрүүд энэхүү Конвенцийн бусад заалтыг харгалзан Хэлэлцэн тохирогч Улс бүр өөрийн хуулийн дагуу татвар ногдуулна.
7. Хэлэлцэн тохирогч аль нэг Улсаас Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суугч техникийн үйлчилгээний орлого олж байгаа бөгөөд түүний жинхэнэ эзэмшигч ба түүндээ Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад

татвар төлдөг бол эхэнд дурдсан Хэлэлцэн тохирогч Улс уг орлогын нийт дүнгийн 5 хувиас хэтрэхгүй хувиар татвар ногдуулж болно.

8. Энэ зүйлд дурдсанаар, “техникийн үйлчилгээний орлого” гэдэг нь техникийн, удирдлагын буюу зөвлөгөө өгөх аливаа үйлчилгээ үзүүлсний төлөө төлбөр хийж буй этгээдээс, ажиллагсдаас бусад аливаа этгээдэд олгож байгаа төлбөр юм.

### 13 дугаар зүйл

#### ХӨРӨНГӨ БОРЛУУЛСНЫ ОРЛОГО

1. Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугч Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байгаа энэхүү Конвенцийн 6 дугаар зүйлд хамаарах үл хөдлөх хөрөнгийг худалдаж борлуулснаас олсон орлогод нөгөө Улсад татвар ногдуулж болно.
2. Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгжийн Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дахь төлөөлөгчийн газрын үйл ажиллагаанд ашиглагддаг хөдлөх хөрөнгийн зарим хэсэг буюу Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугчаас Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад бие даасан хувийн үйлчилгээ явуулах зорилгоор ашиглаж буй товлосон газарт харъяалагдах хөдлөх хөрөнгийг худалдаж борлуулснаас орох орлого, мөн түүнчлэн ийм төлөөлөгчийн газар (дангаар эсвэл бүх аж ахуйн газрын хамт) буюу ийм товлосон газрыг худалдаж борлуулснаас орох орлогод нөгөө Улсад татвар ногдуулж болно.
3. Олон улсын шугамд ашиглагдаж байсан хөлөг онгоц, нисэх онгоц, хуурай болон төмөр замын тээврийн хэрэгсэл буюу эдгээр хөлөг онгоц, нисэх онгоц, хуурай болон төмөр замын тээврийн хэрэгслийн үйл ажиллагаанд хамаарагдах хөдлөх хөрөнгө худалдаж борлуулснаас олсон орлогод ийм тээврийн хэрэгслийг ашиглаж буй тухайн аж ахуйн нэгжийн голлох удирдлага байрладаг Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулж болно. Хэрэв хөлөг онгоцны аж ахуйн нэгжийн голлох удирдлага нь хөлөг онгоцон дээрээ байрладаг бол уг хөлөг онгоцны харъяалах боомт оршдог Хэлэлцэн тохирогч Улсад байрладаг гэж үзнэ, хэрэв харъяалах боомт үгүй бол уг хөлөг онгоцны эзэмшигч байнга оршин сууж байгаа Хэлэлцэн тохирогч Улсад гэж үзнэ.
4. Энэ зүйлийн 1, 2 ба 3 дугаар заалтад хамаарахгүй аливаа хөрөнгийг худалдаж борлуулснаас олсон орлогод худалдан борлуулагчийн байнга оршин суудаг зөвхөн тэр Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулна.

### 14 дүгээр зүйл

#### БИЕ ДААСАН ХУВИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

1. Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суугчаас мэргэжлийн үйлчилгээ үзүүлсэн, эсвэл бие даасан шинжтэй аливаа бусад үйл ажиллагаа эрхлэн олсон орлогод зөвхөн энэхүү Хэлэлцэн тохирогч

Улсад татвар ногдуулна. Гэхдээ уг орлогод дараах нөхцөлд Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар ногдуулж болно:

а) хэрэв байнга оршин суугч нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад өөрийн үйл ажиллагааг явуулахад байнга ашиглаж болох товлосон газартай бол Хэлэлцэн тохирогч нөгөө Улс түүний орлогын зөвхөн товлосон газарт хамаарах хэсэгт татвар ногдуулж болох буюу;

б) хэрэв байнга оршин суугчийн Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байсан нийт хугацаа нь тухайн санхүүгийн жилд эхэлсэн буюу дууссан аливаа 12 сард 183 өдөр буюу түүнээс давсан бол энэ хугацаанд явуулсан үйл ажиллагаанд ногдох орлогод Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар ногдуулж болно.

2. "Мэргэжлийн үйлчилгээ" гэж шинжлэх ухаан, уран зохиол, соёл, урлаг, боловсрол болон багшлах бие даасан үйл ажиллагаа, түүнчлэн эмч, мэс засалч, хууль, инженер, архитекторч, шүдний эмч болон нягтлан бодогч нарын бие даасан үйл ажиллагааг хэлнэ.
3. Энэхүү Конвенцийн дагуу «товлосон газар» гэж хувь хүний бие даасан хувийн үйлчилгээг хэсэгчилэн буюу бүхэлдээ явуулдаг албан тасалгаа буюу өрөө болох товлосон газрыг хэлнэ.

### 15 дугаар зүйл

#### БИЕ ДААСАН БУС ХУВИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

1. Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад ажил үйлчилгээ эрхлээгүйгээс бусад тохиолдолд Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугчийн ажил хийж авсан цалин хөлс болон түүнтэй адилтгах бусад шагнал урамшилд 16, 18, 19 ба 20 дугаар зүйлд заасанчлан зөвхөн Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулна. Хэрэв ажил үйлчилгээг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад гүйцэтгэж байгаа бол тэрхүү ажил үйлчилгээнээс олсон шагнал урамшилд нөгөө Улсад татвар ногдуулж болно.
2. Энэхүү зүйлийн 1 дүгээр заалтыг үл харгалзан Хэлэлцэн тохирогч Улсын оршин суугч Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад гүйцэтгэж буй ажил үйлчилгээний хөлсөнд олгосон шагнал урамшилд Хэлэлцэн тохирогч эхний Улсад дор дурдсан нөхцөлд татвар ногдуулна.
  - а) шагнал урамшил авагч нь тухайн санхүүгийн жилд эхэлсэн буюу дууссан аливаа 12 сарын хугацаанд нийтдээ 183 өдрөөс илүүгүй хугацаагаар Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байсан бол, болон
  - б) шагнал урамшлыг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суудаггүй ажил олгогч өөрөө, эсвэл түүний нэрийн өмнөөс төлсөн бол, болон

в) шагнал урамшлыг ажил олгогчийн Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дахь төлөөлөгчийн газар буюу товлосон газар нь төлөөгүй бол.

3. Энэхүү зүйлийн өмнөх заалтуудыг үл харгалзан, Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгжээс олон улсын шугамд тээвэр хийж буй хөлөг онгоц, нисэх онгоц, хуурай болон төмөр замын тээврийн хэрэгсэл дотор гүйцэтгэсэн ажил үйлчилгээнд зөвхөн тухайн аж ахуйн нэгжийн голлох удирдлага нь байрладаг Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулна.

#### 16 дугаар зүйл

### ЗАХИРЛУУДЫН ШАГНАЛ УРАМШИЛ

Хэлэлцэн тохирогч Улсын оршин суугч Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дахь компанийн Захирлуудын зөвлөл, "бестүүрдер", "коммиссарис" болон "төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн"-ий хувьд авсан цалин болон бусад төрлийн шагнал урамшилд нөгөө Улсад татвар ногдуулж болно.

#### 17 дугаар зүйл

### УРЛАГИЙН АЖИЛТНУУД БА ТАМИРЧИД

1. Энэхүү Конвенцийн 14 ба 15 дугаар зүйлийн заалтуудыг үл харгалзан Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суугч театр, кино жүжигчин, радио буюу телевизийн урлагийн ажилтан, хөгжимчин буюу тамирчин Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад хувийн тоглолт хийж олсон орлогод Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар ногдуулж болно.
2. Энэхүү Конвенцийн 7, 14 ба 15 дугаар зүйлийн заалтуудыг үл харгалзан, урлагийн ажилтан, тамирчны олсон орлого өөрт нь биш бусад этгээдэд ногдож байгаа тохиолдолд уг орлогод тоглолт болсон тухайн Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулна.
3. Энэхүү зүйлийн 1 ба 2 дугаар заалтууд нь Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугчийн Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад явуулсан, Хэлэлцэн тохирогч Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн улсын сангаас бүхэлдээ эсвэл ихэнх нь санхүүжигдсэн, эсвэл Хэлэлцэн тохирогч хоёр Улсын Засгийн газар хоорондын соёлын хамтын ажиллагааны гэрээний дагуу хийгдсэн үйл ажиллагаанаас олсон орлогод хамаарахгүй. Энэ тохиолдолд уг орлогод зөвхөн тухайн жүжигчин буюу тамирчны байнга оршин суудаг Хэлэлцэн тохирогч Улс татвар ногдуулна.

#### 18 дугаар зүйл

ТЭТГЭВЭР, ТОДОРХОЙ ХУГАЦААНЫ ШАГНАЛ УРАМШИЛ,  
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТӨЛБӨР

1. Энэхүү Конвенцийн 19 дүгээр зүйлийн 2 дугаар заалтын дагуу Хэлэлцэн тохирогч Улсаас Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суугч этгээдийн урьд хийж байсан ажилтай нь холбоотой олгосон тэтгэвэр буюу нийгмийн даатгалын хуулийн заалтын дагуу төлөгдсөн бусад төлбөр, тодорхой хугацааны шагнал урамшилд ба өмнө дурдагдсан тэтгэврийн оронд төлөгдөх мөнгөн төлбөрт зөвхөн эхэнд дурдагдсан Улсад татвар ногдуулна.
2. Хэрэв тэтгэвэртэй холбогдсон төлбөр буюу олговор эсвэл бусад адилтгах урамшил, нийгмийн даатгалын тэтгэвэр буюу төлбөр, тодорхой хугацааны шагнал урамшил буюу аливаа мөнгөн төлбөрийг тухайн Улсад 1 дүгээр заалтад дурдсан татварын урамшуулал эдлүүлэхээр байвал тэтгэвэр буюу бусад адилтгах урамшил эсвэл тодорхой хугацааны урамшлыг Хэлэлцэн тохирогч Улсаас олсон гэж тооцно. Хэлэлцэн тохирогч Улс дахь тэтгэврийн сан буюу даатгалын компаниас Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын тэтгэврийн сан буюу даатгалын компанид шилжүүлсэн төлбөрт энэхүү зүйлийн дагуу эхэнд дурдсан Улсад татвар ногдуулах эрхийг аливаа байдлаар хязгаарлахгүй.
3. «Тодорхой хугацааны шагнал урамшил» гэж мөнгөөр буюу мөнгөөр илэрхийлэгдсэн эд зүйлсээр төлөөлүүлэн олгохоор хүлээсэн үүргийн дагуу үе үе тодорхой хугацаанд амьдралын нь турш тогтсон буюу тодорхой хугацаагаар хувь этгээдэд олгодог тогтмол төлбөр.
4. Тэтгэвэр буюу түүнтэй адилтгах урамшил нь энэхүү зүйлд буюу 19 дүгээр зүйлд хамаарах эсэх нь тэтгэвэр болон түүнтэй адилтгах урамшлын тухайн хэсэг нь бий болсон урьд хийж байсан ажлын шинж чанараар (хувийн, улсын) тодорхойлогдоно.

#### 19 дүгээр зүйл

#### ЗАСГИЙН ГАЗРЫН АЛБА

1. а) Хэлэлцэн тохирогч Улсын Засгийн газар буюу түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид алба хашиж байсны хувьд хувь хүнд олгох тэтгэврээс бусад цалин, хөлс болон түүнтэй адилтгах шагнал урамшилд зөвхөн тэр Улсад татвар ногдуулна.  
б) Гэхдээ хэрэв уг ажил үйлчилгээг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад гүйцэтгэсэн бөгөөд уг хувь хүн нь мөн тэр Улсын байнга оршин суугч бол дараах тохиолдолд түүнд олгох цалин, хөлс түүнтэй адилтгах шагнал урамшилд зөвхөн Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар ногдуулна. Уг хувь хүн:
  - i/ нөгөө Улсын харъяат бол,
  - ii/ гагцхүү алба хаших үүднээс тэр Улсын байнга оршин суугч болоогүй бол.



2. а) Хэлэлцэн тохирогч Улсын Засгийн газар буюу түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид алба хашиж байсны хувьд хувь хүнд Хэлэлцэн тохирогч Улсын Засгийн газар буюу түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн сангаас олгосон аливаа тэтгэвэрт зөвхөн тэр Улсад татвар ногдуулна.  
б) Гэхдээ уг хувь хүн нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын байнга оршин суугч бөгөөд тэр улсын харъяат бол дээр дурдсан тэтгэвэрт зөвхөн Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар ногдуулна.
3. Хэлэлцэн тохирогч Улсын Засгийн газар буюу түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээс аж ахуйн үйл ажиллагаа явуулахтай холбоотой алба хаасны хувьд олгосон цалин, хөлс түүнтэй адилтгах шагнал урамшил болон тэтгэвэрт 15, 16 ба 18 дугаар зүйлийн заалтууд хамаарна.

#### 20 дугаар зүйл

### БАГШ НАР БОЛОН ПРОФЕССОРУУД

1. Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугч профессор, багш нар Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын их сургууль, коллеж, боловсролын болон эрдэм шинжилгээ судалгааны байгууллагад 2 хүртэлх жилийн хугацаагаар хичээл заах буюу судалгаа хийх үндсэн зорилгоор Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байгаа бол түүний хичээл зааж, судалгаа хийж олсон орлогод Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулна.
2. Энэ зүйлийн заалт нь олон нийтийн эрх ашгийн төлөө бус хувь этгээдийн эрх ашгийн төлөө хийсэн судалгаанаас бий болсон орлогод хамаарахгүй.

#### 21 дүгээр зүйл

### ОЮУТНУУД БОЛОН ДАДЛАГА ХИЙГЧИД

Хэлэлцэн тохирогч Улсад ирэхийнхээ өмнө Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын байнга оршин суугч байсан буюу одоо хэвээр байгаа бөгөөд Хэлэлцэн тохирогч Улсад гагцхүү суралцах, боловсрол эзэмших, дадлага хийх зорилгоор ирсэн оюутан, сурагч буюу дадлага хийгчид өөрийгөө тэжээх, суралцах буюу дадлага хийхдээ зориулан олсон дараах тэтгэлэгт Хэлэлцэн тохирогч Улс татвар ногдуулахгүй:

- а) Хэлэлцэн тохирогч Улсаас гадна эх үүсвэрээс бий болсон төлбөр;
- б) Хэлэлцэн тохирогч хоёр Улсуудын аль нэг Засгийн газар, эсвэл шинжлэх ухааны, боловсролын, соёлын болон ашгийн бус байгууллагаас олгосон сургалтын тэтгэлэг, тэтгэмж болон шагнал.

22 дугаар зүйл

**БУСАД ОРЛОГО**

1. Конвенцийн өмнөх зүйлүүдэд хөндөгдөөгүй Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суугчийн олж буй аливаа орлогод зөвхөн Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулна.
2. Хэрэв орлого олгогч нь Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугч бөгөөд Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дахь төлөөлөгчийн газраараа дамжуулан үйл ажиллагаа явуулж байгаа буюу Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дахь товлосон газраар дамжуулан бие даасан хувийн үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд уг орлоготой холбогдсон эрх ба эд хөрөнгө нь энэ төлөөлөгчийн газар буюу товлосон газартай шууд холбоотой бол 6 дугаар зүйлийн 2 дугаар заалтад тодорхойлогдсон үл хөдлөх хөрөнгийн орлогоос бусад орлогын хувьд энэхүү зүйлийн 1 дүгээр заалтыг баримтлахгүй. Энэ тохиолдолд 7 эсвэл 14 дүгээр зүйлийн аль тохиромжтойг хэрэглэнэ.

**4 дүгээр бүлэг**

**ТАТВАРЫН ДАВХАРДЛААС СЭРГИЙЛЭХ**

23 дүгээр зүйл

**ДАВХАР ТАТВАР НОГДУУЛАХГҮЙ БАЙХ**

1. Энэхүү Конвенцийн заалтуудын дагуу Монгол Улсад байнга оршин суугч Нидерланд Улсад татвар ногдуулж болох орлого олж байвал Монгол Улс тус оршин суугчийн татвараас Нидерланд Улсад төлсөн татвартай тэнцэх хэмжээгээр хасалт хийнэ. Гэхдээ энэ хасалт нь Нидерланд Улсад татвар ногдуулж болох орлоготой холбоотой хасалт хийхээс өмнө тооцоолсон орлогын татварын хэсгээс хэтэрч болохгүй.
2. Энэхүү Конвенцийн аливаа заалтын дагуу Монгол Улсад байнга оршин суугчийн олсон орлого нь Монгол Улсын татвараас чөлөөлөгдсөн бол Монгол Улсад тухайн байнгын оршин суугчийн үлдэгдэл орлогод ногдох татварыг тооцоолохын чөлөөлөгдсөн орлогыг оруулан тооцоолно.
3. Нидерланд Улсад байнгын оршин суугч энэхүү Конвенцийн заалтын дагуу Монгол Улсад татвар ногдуулж болох орлогын төрлүүдийг олж байвал Нидерланд Улсад байнга оршин суугчдийнхаа татвар ногдох орлогыг тооцохдоо дээрх орлогыг оруулж тооцно.
4. Энэхүү Конвенцийн 6 дугаар зүйл, 7 дугаар зүйл, 10 дугаар зүйлийн 6 дугаар заалт, 11 дүгээр зүйлийн 5 дугаар заалт, 12 дугаар зүйлийн 4 дүгээр заалт, 13 дугаар зүйлийн 1 ба 2 дугаар заалт, 14 дүгээр зүйл, 15 дугаар зүйлийн 1 дүгээр заалт, 19 дүгээр зүйлийн 1 («а» дэд заалт) ба 2 («а» дэд заалт) дугаар заалт, 22 дугаар зүйлийн 2 дугаар

Монгол Улсад татвар ногдуулж болохуйц орлогын төрлүүдийг олж байвал, тэдгээрийг 1 дүгээр заалтын татварын орлогод оруулж тооцсон бол Нидерланд Улс энэ орлогыг хасах аргаар татварыг бууруулж тооцно. Ингэж бууруулж тооцох нь давхар татвараас зайлсхийх тухай Нидерланд Улсын хуулийн заалтуудад нийцэж байх ёстой. Энэ зорилгоор Конвенцийн заалтуудад дээрх орлогын төрлийг Нидерланд Улсын татвараас чөлөөлөгдөж байгаа орлогын төрлийн дүнд оруулж тооцож байгаа болно.

5. Нидерланд Улсад энэхүү Конвенцийн 10 дугаар зүйлийн 2 дугаар заалт, 11 дүгээр зүйлийн 2 дугаар заалт, 12 дугаар зүйлийн 2 ба 7 дугаар заалтууд, 16 дугаар зүйл, 17 дугаар зүйл, 18 дугаар зүйлийн 1 дүгээр заалтуудтай холбоотой Монгол Улсад татвар ногдуулж болохуйц, энэ зүйлийн 1 дүгээр заалтын татварын орлогод оруулж тооцсон орлогын төрлийн хүрээний орлогод тогтоосон татварыг Нидерланд Улсын татвараас хасч тооцохыг зөвшөөрч болно. Энэхүү хасалт нь дээрх орлогын төрлөөр Монгол Улсад төлсөн татвартай ижил хэмжээтэй байх ёстой бөгөөд харин Нидерланд Улсад давхар татвараас зайлсхийх тухай хуулийн заалтуудаар зөвшөөрөгдөж байгаа бөгөөд татварын орлогод оруулж тооцсон орлогын төрлүүд нь Нидерланд Улсын давхар татвараас зайлсхийх тухай хуулийн дагуу тус Улсын татвараас хасагддаг орлогын онцгой төрлүүд бол бууруулж болох дүнгээс хэтрэх ёсгүй.

Энэ заалт Нидерланд Улсын давхар татвараас зайлсхийх тухай хуулийн заалтуудаар олгогдсон боломжийг одоо болоод цаашид хязгаарлах ёсгүй.

Монгол Улсын эдийн засгийг хөгжүүлэх дэмжих онцгой арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилгоор 11 дүгээр зүйлийн 2 дугаар заалтад дурдсан орлогын хувьд Монгол Улсын татварыг хөнгөлөхдөө тус орлогын нийт дүнгийн 10 хувьтай тэнцүү байна гэж тооцно. Энэ заалт энэхүү Конвенцийг хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрийн дараагаас зөвхөн 10 жилийн хугацаанд хүчинтэй байна. Дээрх хугацааг эрх бүхий байгууллагууд харилцан зөвшилцөөд сунгаж болно.

## 5 дугаар бүлэг

### БУСАД ЗААЛТУУД

#### 24 дүгээр зүйл

### ОФШОР ҮЙЛ АЖИЛЛАГАА

1. Энэхүү Конвенцийн аливаа бусад заалтуудыг үл харгалзан энэхүү зүйлийн заалтуудыг баримтлана. Гэхдээ 5 дугаар зүйлийн заалтуудын дагуу байнгын байрлалтай этгээд эсвэл 14 дүгээр зүйлийн заалтуудын дагуу товлосон газартай этгээдэд энэ зүйл хамаарахгүй.

3. Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгж нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад офшор үйл ажиллагаа явуулж байвал 4 дүгээр зүйлд зааснаар нөгөө улсад төлөөлөгчийн газраар дамжуулан үйл ажиллагаагаа явуулж байна гэж үзнэ. Харин аливаа 12 сарын хугацаанд дахь нийт 30 хоногоос хэтрэхгүй хугацаанд нөгөө Улсад офшор үйл ажиллагаа явуулсан бол төлөөлөгчийн газартай гэж үзэхгүй.

Энэхүү заалтад нийцүүлэн:

а) хэрэв аж ахуйн нэгж Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад офшор үйл ажиллагааг өөр аж ахуйн нэгжтэй хамтран явуулж байгаа бөгөөд тэр өөр аж ахуйн нэгж нь нэг төслийн нэг хэсгийг гүйцэтгэж байгаа буюу эхний аж ахуйн нэгжийн явуулж байгаа болон явуулсан тухайн офшор үйл ажиллагааг үргэлжлүүлсэн бол тус хоёр аж ахуйн нэгж энэхүү үйл ажиллагаануудыг хамтран явуулсан хугацааг нийлүүлж үзэхэд 30 өдрөөс давж байвал аж ахуйн нэгж бүр аливаа 12 сарын хугацаан дахь 30 өдрөөс дээш хугацаанд үйл ажиллагаа явуулсан гэж үзнэ;

б) хэрэв нэг аж ахуйн нэгж нь нөгөө аж ахуйн нэгжийн хөрөнгийн дор хаяж гуравны нэгийг шууд буюу шууд бусаар эзэмшиж байвал эсвэл хувь этгээд хоёр аж ахуйн нэгжийн хоёулангийнх нь хөрөнгийн дор хаяж гуравны нэгийг шууд буюу шууд бусаар эзэмшиж байвал аж ахуйн нэгжийг нөгөө аж ахуйн нэгжтэй харьяа гэж үзнэ.

4. Гэхдээ энэ зүйлийн 3 дугаар заалттай нийцүүлэн "офшор үйл ажиллагаа" гэдэгт дараах үйл ажиллагааг үл хамааруулна:

а) 5 дугаар зүйлийн 4 дэх заалтад дурдсан үйл ажиллагаа ба үйл ажиллагааны аливаа хослол;

б) түр зогсолтыг гүйцэтгэдэг хөлөг онгоц ба уг хөлөг онгоцоор гүйцэтгэж буй аливаа бусад үйл ажиллагаа;

в) олон улсын шугамд хөлөг онгоц буюу нисэх онгоцоор ачаа буюу хүн тээвэрлэлт.

5. Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суугч Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад мэргэжлийн үйлчилгээ буюу бие даасан шинж чанартай бусад үйл ажиллагааг агуулсан офшор үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд энэхүү офшор үйл ажиллагаа нь 30 өдөр ба түүнээс дээш хугацаанд үргэлжилж байвал нөгөө Улсад товлосон газраар дамжуулан үйл ажиллагаа явуулж байна гэж үзнэ.

6. Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байрладаг төлөөлөгчийн газраар дамжуулан офшор үйл ажиллагаа явуулж байгаатай холбогдсон ажил эрхлэлтээс Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суугчид олгох цалин, хөлс түүнтэй адилтгах шагнал урамшилд нөгөө Улс татвар ногдуулж болно.

### 25 дугаар зүйл

#### ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХ ЯВДАЛ ГАРГАХГҮЙ БАЙХ

1. Хэлэлцэн тохирогч Улсын харъяат Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар төлөх болон түүнтэй холбоотой бусад шаардлагын хувьд Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын харъяатаас, ялангуяа байнгын оршин суугч биш гэдэг талаасаа татварын адилгүй буюу илүү хүндрэлтэй нөхцөлд байх ёсгүй.
2. Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгжийн Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байрладаг төлөөлөгчийн газрын татвар төлөх нөхцлийг нөгөө Улсад түүнтэй адилтгах төрлийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн татвар төлөх нөхцлөөс доор байлгаж болохгүй. Энэ заалт нь Хэлэлцэн тохирогч Улс нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын байнга оршин суугчдад иргэний эрх, гэр бүлийн хариуцлагын хувьд өөрийн байнга оршин суугчидынхаас өөр татвараас чөлөөлөх, хөнгөлөх, багасгах эрх эдлүүлэх ёстой гэсэн утгаар хэрэглэгдэхгүй.
3. 9 дүгээр зүйлийн 1 дүгээр заалт, 11 дүгээр зүйлийн 7 дугаар заалт, 12 дугаар зүйлийн 6 дугаар заалтыг хэрэглэхээс бусад тохиолдолд Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгжийн татвар ногдох ашгийг тодорхойлохдоо тухайн аж ахуйн нэгжээс Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суугч этгээдэд төлж буй хүү, эрхийн шимтгэл болон бусад төлбөрийг эхний Улсын байнга оршин суугч этгээдэд төлсөнтэй адил нөхцлөөр хасч хөнгөлнө. Үүний нэгэн адилаар, Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгжийн татвар ногдох хөрөнгийг тодорхойлохдоо тухайн аж ахуйн нэгжээс Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын байнга оршин суугчид төлсөн аливаа өрийг Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугчийн хувьд тохиролцсонтой адил нөхцлөөр хасч тооцно.
4. Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгжийн хөрөнгийг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын байнга оршин суугч нэг буюу хэсэг этгээд шууд буюу шууд бусаар бүхэлд нь, эсвэл хэсэгчлэн өмчилж буюу хянаж байвал Хэлэлцэн тохирогч Улс өөрийн адил төрлийн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн татвар төлөх буюу түүнтэй холбоотой шаардлагаас өөр буюу илүү хүндрэлтэй байдалд оруулах хариуцлага ногдуулахгүй.
5. Энэ зүйлийн заалтууд нь 2 дугаар зүйлийн заалтуудыг үл харгалзан бүх төрөл, зүйлийн татварт хамаарна.

## 26 дугаар зүйл

### ХАРИЛЦАН ТОХИРОХ ЖУРАМ

1. Хэрэв хувь этгээдэд Хэлэлцэн тохирогч аль нэг Улс буюу хоёр Улс хоёулаа энэхүү Конвенцид заагдаагүй татвар түүнд ногдуулсан буюу ногдуулах боллоо гэж үзвэл тухайн Улсуудын дотоодын хууль тогтоомжийн заалтуудыг үл харгалзан өөрийн байнга оршин суугаа Хэлэлцэн тохирогч Улсынхаа эрх бүхий байгууллагад буюу хэрэв тухайн тохиолдол нь 25 дугаар зүйлийн 1 дүгээр заалтад хамаарч байвал өөрийн харъяат Хэлэлцэн тохирогч Улсад гомдлоо гаргаж болно. Гомдлыг энэхүү Конвенцид заагдаагүй татвар ногдуулж байна гэж анх мэдсэнээс хойш 3 жилийн дотор гаргана.
2. Гомдлыг нотлож хангалттай шийдвэр гаргах боломжгүй бол Хэлэлцэн тохирогч хоёр Улсын эрх бүхий байгууллага энэхүү Конвенцид заагдаагүй татвар ногдуулахгүй байх зорилгоор харилцан тохирох бүх арга хэмжээ авна. Аливаа тохиролцоог Хэлэлцэн тохирогч Улсуудын хууль тогтоомжийн цаг хугацааны хязгаарлалтыг үл харгалзан хэрэгжүүлнэ.
3. Хэлэлцэн тохирогч Улсуудын эрх бүхий байгууллагууд нь энэхүү Конвенцийг хэрэглэх болон тайлбарлахад үүсэх аливаа хүндрэлтэй болон эргэлзээтэй асуудлуудыг харилцан тохирох замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Мөн түүнчлэн энэхүү Конвенцид заагдаагүй орлогыг давхар татвараас чөлөөлөх асуудлыг тэд харилцан зөвлөлдөж болно.
4. Хэлэлцэн тохирогч Улсуудын эрх бүхий байгууллагууд нь өмнөх заалтуудын талаар тохиролцоонд хүрэх зорилгоор өөр хоорондоо шууд харилцаж болно.

## 27 дугаар зүйл

### ХАРИЛЦАН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ

Хэлэлцэн тохирогч хоёр Улсын эрх бүхий байгууллагууд энэхүү Конвенцид хамаарагдах татварын талаарх хоёр Улсын хууль тогтоомж болон уг Конвенцийн заалтуудыг биелүүлэхэд шаардагдах мэдээллийг харилцан солилцож байна. Хоёр улсын татварын талаархи хууль тогтоомж, татвар ногдуулалт нь энэхүү Конвенц түүний дотор татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд харшлах ёсгүй. Харилцан мэдээлэл солилцох явдлыг 1 дүгээр зүйлээр хязгаарлахгүй. Хэлэлцэн тохирогч Улс Хэлэлцэн тохирогч нөгөө Улсаас хүлээн авсан мэдээллийг Хэлэлцэн тохирогч Улс өөрийн улсын мэдээлэл хадгалах хуулийн дагуу нууцалж зөвхөн энэхүү Конвенцид хамаарагдах татварын хэмжээг тогтоох буюу хураахтай холбогдсон этгээдүүд, эрх барих байгууллагуудад (шүүх, захиргааны байгууллагыг оролцуулан) мэдэгдэх эрхтэй. Тэдгээр этгээд буюу

эрх барих байгууллагууд нь уг мэдээллийг зөвхөн энэхүү зорилгод ашиглана. Түүнчлэн тэд дээрх мэдээллийг олон нийтийн шүүхийн протокол, шүүхийн шийдвэрт тусгаж болно.

## 28 дугаар зүйл.

### ТАТВАР ХУРААХАД ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ

1. Хэлэлцэн тохирогч Улсууд тус бүрийн хууль буюу захиргааны хэвшсэн үйл ажиллагааны дагуу энэхүү Конвенцид хамаарах татвар, түүний аливаа нэмэгдэл, хугацаа хэтрүүлсний төлбөр, хүүг хураах болон дээр дурдсан татваруудтай холбоотой зардлуудыг тооцоход бие биендээ туслалцаа, дэмжлэг үзүүлнэ.
2. Хүсэлт гаргагч Хэлэлцэн тохирогч Улсын хүсэлтийн дагуу хүсэлт хүлээн авагч Хэлэлцэн тохирогч нөгөө Улс нь өөрийн татварын хууль болон захиргааны хэвшсэн үйл ажиллагааны дагуу өөрийн хүсэлтийг барагдуулдагын нэгэн адил эхэнд дурдагдсан Улсын татварын нэхэмжлэлийг барагдуулна. Гэхдээ энэхүү нэхэмжлэл нь хүсэлт гаргагч талд ямар нэгэн давуу тал олгохгүй бөгөөд өртэй этгээдийг хорих замаар барагдуулж болохгүй. Хүсэлтийг хүлээн авагч Улс нь хүсэлт гаргагч Улсын хуульд заагаагүй аливаа гүйцэтгэх арга хэмжээг авч үл болно.
3. Энд дурдагдаагүй бөгөөд хоёр талын эрх бүхий байгууллагууд хоорондоо өөрөөр тохиролцоогүй бол энэхүү Конвенцийн 2 дугаар заалт нь хүсэлт гаргагч Улсад хүчээр хэрэгжүүлэхэд зөвшөөрөгдсөн арга ажиллагааны дагуу өгч болох татварын нэхэмжлэлд хамаарна.  
Гэхдээ эрх бүхий байгууллагууд хоорондоо өөрөөр тохироогүй, татварын нэхэмжлэл нь зөрчилдөхгүй байгаа тохиолдолд тухайн нэхэмжлэл нь хүсэлт гаргагч Улсад байнга оршин суугч бус этгээдийн татварын үүрэгтэй холбоотой бол 2 дугаар заалтад хамаарна.
4. Хүсэлтийг хүлээн авагч Улс нь хүсэлтийг хүлээн авахгүй байх нөхцөл нь:
  - а) хэрэв хүсэлт гаргагч Улс нь өөрийн нутаг дэвсгэрт байгаа бүх боломжийг ашиглаагүй. Гэхдээ ийм боломж нь маш их хүндрэлийг бий болгож байгаа тохиолдлоос бусад.
  - б) хэрэв нэхэмжлэгдэж буй татвар нь энэхүү Конвенц болон хоёр Улсын хооронд байгуулагдсан аливаа гэрээ хэлэлцээрийн заалттай зөрчилдөж байвал.
5. Хүсэлт хүлээн авагч Улсын хуулийн дагуу хүлээн зөвшөөрөгдөхөөр байвал туслалцаа үзүүлэхийг хүссэн хүсэлтийг хүлээн авсан даруйд хүсэлт гаргагч Улс хүчээр хэрэгжүүлэх арга ажиллагааг хүлээн авах, зөвшөөрөх, нэмэлт хийх, өөрчлөхөө аль болох богино хугацаанд авч хэрэгжүүлнэ.
6. Энэхүү зүйлийн хэрэгжилттэй холбоотой журмын талаар Улсуудын эрх бүхий байгууллагууд нэгдсэн тохиролцоотой байх ёстой.

27 БОЛОН 28 ДУГААР ЗААЛТЫН ХЯЗГААРЛАЛТ

1. Ямарч тохиолдолд 27 болон 28 дугаар зүйлүүдийн заалтууд нь Хэлэлцэн тохирогч Улсад дараах үүргийг хүлээлгэхгүй:

а) Хэлэлцэн тохирогч Улс болон Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээнд харшлах захиргааны арга хэмжээ авах;

б) Хэлэлцэн тохирогч Улс болон Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын хууль тогтоомж захиргааны ердийн үйл ажиллагааны дагуу олж үл болох мэдээллээр хангах;

в) аливаа худалдаа, аж ахуйн үйл ажиллагаа, аж үйлдвэр, арилжаа буюу мэргэжлийн нууцыг илрүүлэх мэдээ болон нийгмийн хэв журамд харшлах мэдээллээр хангах.

30 дугаар зүйл

ДИПЛОМАТ БА КОНСУЛЫН АЖИЛТНУУД

1. Энэхүү Конвенц нь олон улсын эрх зүйн ерөнхий хэм хэмжээ болон тусгай хэлэлцээрийн заалтуудын дагуу дипломат ба консулын ажилтнуудын санхүүгийн эрх, дархыг үл хөндөнө.

2. Хэлэлцэн тохирогч нөгөө Улс буюу гуравдагч Улсад байрлаж байгаа Хэлэлцэн тохирогч Улсын дипломат байгууллага, консулын газар буюу суурин төлөөлөгчийн газрын ажилтан хувь этгээд нь илгээгч Улсын иргэн бол уг хувь хүн нь илгээсэн Улсдаа, уг Улсын байнга оршин суугчдын нэг адил орлого буюу хөрөнгөндөө татвар төлөх үүрэг хүлээсэн бол энэхүү Конвенцийн хүрээнд түүнийг илгээсэн Улсын байнга оршин суугч гэж үзнэ.

3. Хэлэлцэн тохирогч Улсад оршиж байгаа бөгөөд орлого буюу хөрөнгийн татварын хувьд Хэлэлцэн тохирогч аль ч Улсад байнга оршин суугч гэж тооцогдоогүй олон улсын байгууллагууд буюу тэдгээрийн ажилтнууд болон гуравдагч Улсын дипломат байгууллага, консулын газар буюу суурин төлөөлөгчийн газрын хувь этгээдүүдэд энэхүү Конвенц үл хамаарна.



### 31 дүгээр зүйл

#### ГАЗАР НУТГИЙН ӨРГӨТГӨЛ

1. Энэхүү Конвенцид бүхэлдээ буюу шаардлагатай өөрчлөлт оруулснаар хэрэв энэхүү Конвенцид хамаарагдах татваруудтай адил шинж чанартай татварыг ногдуулж л байвал Нидерландын Антиллс ба Аруба улсад аль нэгэнд нь буюу хоёуланд нь уг Конвенц нэгэн адил хамаарч болно. Энэхүү аливаа өргөтгөл нь аливаа өөрчлөлт болон нөхцөл, түүний дотор дуусгавар болгох нөхцлүүдийг тусган харилцан тохиролцон тодорхойлсон нот бичгийг дипломат шугамаар солилцсон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
2. Өөрөөр тохироогүй бол уг Конвенцийг дуусгавар болгосон нь энэхүү зүйлийн дагуу өргөтгөлд хамрагдсан аливаа Улстай байгуулсан Конвенцийн өргөтгөл хүчингүй болсон гэж үзэхгүй.

### 6 дугаар бүлэг

#### ЭЦСИЙН ЗААЛТУУД

### 32 дугаар зүйл

#### ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

Энэхүү Конвенц нь Хэлэлцэн тохирогч Улс бүрт үндсэн хуулийн шаардлагад нийцсэн талаар Засгийн газрууд дипломатын шугамаар харилцан бичгээр мэдэгдсэнээс хойш 30 дахь хоногт хүчин төгөлдөр болох бөгөөд Конвенцийн заалтууд нь түүнийг хүчин төгөлдөр болсны дараагийн хуанлийн жилийн 1 дүгээр сарын эхний өдрийн дараагаас татварын жилүүдэд мөрдөгдөж эхэлнэ.

### 33 дугаар зүйл


#### ДУУСГАВАР БОЛОХ

Энэхүү Конвенцийг Хэлэлцэн тохирогч аль нэг Улс цуцлах хүртэл хүчин төгөлдөр мөрдөнө. Энэхүү Конвенц хүчин төгөлдөр болсноос хойш 5 жилийн дараах хуанлийн жил дуусахаас 6 сараас өмнө уг Конвенцийг цуцлах тухайгаа Хэлэлцэн тохирогч аль ч Улс дипломат шугамаар бичгээр мэдэгдэж болно. Энэ тохиолдолд, цуцлах тухай мэдэгдлээ өгсөн хуанлийн жил дууссаны дараагаас эхлэх татварын жилээс энэхүү Конвенц хүчин төгөлдөр байхаа болино.


Дээр дурдсаныг нотолж, зохих ёсоор эрх олгогдсон дараах хүмүүс энэхүү Конвенцид гарын үсэг зурав.

2002 оны 3. дугаар сарын 08.-ны өдөр <sup>Улаанбаатар</sup> хотноо Монгол, Нидерланд, Англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна. Гарч болох маргаантай асуудлыг шийдвэрлэхдээ Англи хэл дээрхи эх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН  
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ



НИДЕРЛАНДЫН ВАНТ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ



## Протокол

Монгол Улс, Нидерландын Вант Улсын хоорондын Орлогын татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Конвенцид гарын үсэг зурах үед дараах заалтууд нь Конвенцийн салшгүй хэсэг мөн гэдгийг зөвшөөрөв.

### I. Нэмэлт. 2 дугаар зүйл

Газрын тос, байгалийн хийн салбарт Нидерландын байнга оршин суугч этгээдтэй Монголын Засгийн газрын хийсэн бүтээгдэхүүн хуваах гэрээ буюу түүнтэй адилтгах аливаа гэрээгээр ашиг ба ашгаас төлөгдсөн ногдол ашгийн орлогод Монголын тал ямар нэгэн татвар ногдуулахгүй.

### II. Нэмэлт. 3 дугаар зүйлийн 1 дүгээр заалт, «д» дэд заалт

Хэрэв татварын зорилгоор аж ахуйн нэгж хэмээн тооцогдох нэгж нь Хэлэлцэн тохирогч Улсад татварт хамрагдах ёстой боловч, тухайн нэгжийн орлогод тэр нэгжид оролцож Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад олсон орлогоос Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар ногдуулахаар бол, Хэлэлцэн тохирогч хоёр Улсын эрх бүхий байгууллагууд нэг талдаа давхар татвар ногдуулахгүй байх, нөгөө талдаа энэхүү Хэлэлцээрийн дан ганц үр дүн болох орлогыг (хэсэг нь) татварт хамруулахгүй байхаас сэргийлэх арга хэмжээг авах ёстой. Тухайн нэгжийн орлогын татварыг тус нэгжид оролцогчдын орлогын татвар гэж үзвэл дээр дурдсан орлогын татварыг тодорхойлохдоо, оролцогчдын тухайн нэгжийн хөрөнгөд оруулсантай хувь тэнцүү гэж үзнэ. Мөн түүнчлэн оролцогч бүр тухайн нэгжийн салбараасаа (гурав дахь Улсад суутгалаар төлсөн татварыг оролцуулна) олсон орлогод ногдуулсан албан татварыг тухайн нэгжид оролцсон хэмжээгээр тооцсонтой адилхан орлогод ногдуулах татвараас хасч тооцож болно. Тэгээд, тухайн нэгжийн байнга оршин суудаг Улс тус нэгжийн ашгийг оролцогчдод нь хувиарлахдаа боломжит татварыг хасч болно.

### III. Нэмэлт. 4 дүгээр зүйл

Хувь хүн аль нэг Хэлэлцэн тохирогч Улсад үнэхээр оршин суудаггүй, хөлөг онгоцон дээрээ амьдардаг бол энэхүү хөлөг онгоцны харъяалах боомт оршдог Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугч гэж үзнэ.

### IV. Нэмэлт. 5 дугаар зүйл

5 дугаар зүйлийн 6 дугаар заалтын сүүлчийн өгүүлбэрт дурдсан төлөөлөгчийн үйл ажиллагаа нь бүхэлдээ буюу дийлэнхдээ тухайн аж ахуйн

нэгжийн нэрийн өмнөөс хийгдэж байгаа, төлөөлөгч ба аж ахуйн нэгжийн харилцаа нь ойр төрлийн биш гэдэг нь харагдаж байвал түүнийг бие даасан эрх бүхий төлөөлөгч гэж энэхүү заалтад хамааруулахгүй.

Ү.

Нэмэлт. 5,6,7,13 ба 24 дүгээр зүйлүүд

Далайн ёроол, түүний газрын хэвлий ба тэдгээрийн байгалийн баялгийг олборлох болон ашиглах эрх нь Хэлэлцэн тохирогч Улсад үл хөдлөх хөрөнгө гэж ойлгогдоно. Эдгээр эрхийг тухайн Хэлэлцэн тохирогч Улсын төлөөлөгчийн газрын хөрөнгө гэж үзнэ. Түүнчлэн дээр дурдсан эрхүүдэд түүний хүү, эрхээс олох ашиг, энэхүү олборлолт, ашиглалтаас гарах ашгийг оролцуулж ойлгоно.

ҮI.

Нэмэлт. 7 дугаар зүйл

7 дугаар зүйлийн 1 ба 2 дугаар заалтуудын дагуу Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгж Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад төлөөлөгчийн газраараа дамжуулан бараа буюу эд агуурс борлуулж эсвэл бизнес эрхэлж байвал төлөөлөгчийн газрын ашгийг аж ахуйн нэгжийн олсон нийт дүнд үндэслэж тогтоохгүй, харин тус аж ахуйн нэгжийн тухайн төлөөлөгчийн газрын тийм худалдаа эсвэл бизнесийн үйл ажиллагаа эрхэлж олсон орлогын хэмжээнд үндэслэж тодорхойлно. Ялангуяа судалгаа хийх, нийлүүлэх, аж үйлдвэр, арилжаа, шинжлэх ухааны тоног төхөөрөмж суурилуулах болон байгуулах эсвэл төрийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийн хувьд, тухайн аж ахуйн нэгж нь төлөөлөгчийн газартай бол тус төлөөлөгчийн газартай холбоотой ашиг нь гэрээний нийт дүнд үндэслэж тогтоогдохгүй, харин гэрээний Хэлэлцэн тохирогч Улсад байгаа төлөөлөгчийн газраар хийгдсэн хэсгийг үндэслэн тогтооно. Толгой аж ахуйн нэгжийн гэрээгээр хийгдсэн хэсэгт ногдох ашигт зөвхөн тухайн аж ахуйн нэгжийн байнга оршин суугч Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулна.

ҮII.

Нэмэлт. 10 дугаар зүйл

10 дугаар зүйлийн 3 дугаар заалтад дурдсан ногдол ашиг нь оролцогчийн чөлөөлөлтөөр Нидерланд Улсын компанийн татвараас чөлөөлөгдөнө гэж ойлгоно.

ҮIII.

Нэмэлт. 10 дугаар зүйл

1. 10 дугаар зүйлийн (1) ба (2) дугаар заалтуудыг үл харгалзан тухайн Улсын хуулиар хувьцаагаар хөрөнгө нь хуваагдсан тус Улсын байнга оршин суугч компаний нөгөө Улсын байнга оршин суугч хувь хүнд төлсөн ногдол ашигт, хэрэв тэр хувь хүн дангаараа эсвэл түүний эхнэр болон нөхөр эсвэл тэдний шууд цусны болон гэрлэсэн хамаатан нь тухайн компаний нэг төрлийн

хувьцааны хөрөнгийн 5 буюу түүнээс дээш хувийг шууд болон дамжуулан эзэмшиж байвал эхний Улсад татварыг хуулийн дагуу ногдуулж болно. Энэ заалт ногдол ашиг авсан хувь хүн Нөгөө Улсын байнга оршин суугч болох үед, ногдол ашиг өгөгдөж, төлөгдсөн жилээс урдах 10 жил эхний Улсад байнга оршин суугч байсан тохиолдолд хамаарна. Уг аж ахуйн нэгжид дээр дурдсан хувьцааны эзэмшлийн нөхцлийг хангасан байх ёстой.

Дурдсан эхний Улсын дотоодын хуулийн дагуу дээрх хувьцааг худалдсантай холбогдуулан хувь хүнд төлсөн ногдол ашгийн үнэлгээг тухайн хүнийг эхний Улсаас цагаачилж гарсан мөчид худалдсанаар тооцож үнэлгээг үнэлгээний хэсгийг шийдтэл баримтална.

2. Мөн 10 дугаар зүйлийн 6 дугаар заалт энэ заалтын 1 дүгээр заалтад хамаарна.

IX.

Нэмэлт. 10 дугаар зүйл

2 дугаар догол мөрний заалтуудыг үл харгалзан Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугч компаниас төлж байгаа ногдол ашгийн жинхэнэ эзэмшигч нь 4 дүгээр зүйлийн 2 дугаар заалтад дурдсан тэтгэврийн сан бол тухайн компаний төлж байгаа ногдол ашигт татвар ногдуулахгүй.

X.

Нэмэлт. 10,11 ба 12 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч Улсын эрх бүхий байгууллагууд нь 10 дугаар зүйлийн 2 ба 3 дугаар заалтууд, 11 дүгээр зүйлийн 2 ба 3 дугаар заалтууд, 12 дугаар зүйлийн 2 ба 7 дугаар заалтуудыг дагаж мөрдөх аргачлалыг харилцан хэлэлцэж тохирно.

XI.

Нэмэлт. 10 ба 11 дүгээр зүйл

Нидерландын хувьд ногдол ашиг гэдэгт бонд хуваасны ашгаас олох орлогыг оролцуулж ойлгоно.

XII.

Нэмэлт. 10 ба 13 дугаар зүйл

Татан буулгасантай (хэсэгчлэн) болон компани өөрийн хувьцаануудаа худалдаж авсантай холбоотой олсон орлогыг хөрөнгө борлуулсны орлогод биш хувьцааны орлогод тооцож ойлгоно.

12 дугаар зүйлийн 2 дугаар заалттай холбогдуулан дотоодынхоо хуулийн дагуу Нидерланд байнга оршин суугч биш хүнд төлсөн эрхийн шимтгэлийн эх үүсвэрт татвар ногдуулдаггүй учраас 12 дугаар зүйлийн 2 дугаар заалт хамаарахгүй ба эрхийн шимтгэлд зөвхөн эрхийн шимтгэлийн жинхэнэ эзэмшигч нь байнга оршин суудаг Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулна.

XIY.

Нэмэлт. 13 дугаар зүйл

1. 13 дугаар зүйлийн (4) дүгээр заалтыг үл харгалзан "худалдах" гэдэг хэллэгийн тайлбарыг агуулсан хуулийн дагуу Хэлэлцэн тохирогч Улсын хуулийн дагуу хувьцаагаар хөрөнгө нь хуваагдсан тус улсын байнга оршин суугч компанаас Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын байнга оршин суугч хувь хүний хувьцаа болон өрийн бичгийг худалдснаас олсон ашиг мөн энэхүү хувьцаа болон өрийн бичгийн зарим эрхийг худалдсанаас олсон ашигт, хэрэв тэр хувь хүн дангаараа эсвэл түүний эхнэр болон нөхөр эсвэл тэдний шууд цусны болон гэрлэсэн хамаатан нь тухайн компаний нэг төрлийн хувьцааны хөрөнгийн 5 буюу түүнээс дээш хувийг шууд болон дамжуулан эзэмшиж байвал Хэлэлцэн тохирогч Улс өөрийн хуулийн дагуу татвар ногдуулна. Энэ заалт ногдол ашиг авсан хувь хүн ногдол ашиг өгөгдөж, төлөгдсөн жилээс урдах 10 жил эхний Улсын байнга оршин суугч байсан тохиолдолд хамаарна. Уг аж ахуйн нэгжид дээр дурдсан хувьцааны эзэмшлийн нөхцлийг хангасан байх ёстой.

Дурдсан эхний Улсын дотоодын хуулийн дагуу дээрх хувьцааг худалдсантай холбогдуулан хувь хүнд төлсөн ногдол ашгийн үнэлгээг тухайн хүнийг эхний Улсаас цагаачилж гарсан мөчид худалдсанаар тооцож үнэлгээг үнэлгээний хэсгийг шийдтэл баримтална.

2. 23 дугаар зүйлийн 3 дугаар заалт мөн 1 дүгээр заалтад хамаарна.

XYY.

Нэмэлт. 16 дугаар зүйл

Компаний "бестүүрдөр", "коммиссарис" болон "төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн" гэдэгт хувьцаа эзэмшигчдийн хурлаар эсвэл тус компаний эрх бүхий хүний томилсон, компаний ерөнхий удирдлага болон хяналтыг хариуцаж байдаг этгээдийг хэлж байгаа гэж ойлгоно.

XYYI.

Нэмэлт. 26 дугаар зүйл


26 дугаар зүйлд дурдсан харилцан тохирох журмын нөхцлүүдийн үндсэн дээр хийсэн аливаа хэлэлцээр нь нэмэгдэл татвар бий болгосон Улсын үндэсний зохих хуульд энэхүү нэмэлт хэлэлцээр нь харшилж байвал уг

Улсад нэмэлт татвартай холбогдуулан аливаа нэмэлт, нэмэгдэл, хүү болон ертгийг ногдуулахгүй бөгөөд нөгөө Улсад уг хэлэлцээрээс хамаарч татварын хасалт бий болвол энэхүү хасалттай холбогдон төлөх ёстой хүүгийн төлбөрөөс түтгэлзэнэ.

Дээр дурдсаныг нотолж, зохих ёсоор эрх олгогдсон дараах хүмүүс энэхүү Протоколд гарын үсэг зурав.

2002 оны 3 дугаар сарын 08-ны өдөр ~~Улаанбаатар~~ хотноо Монгол, Нидерланд, Англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна. Гарч болох маргаантай асуудлыг шийдвэрлэхдээ Англи хэл дээрхи эх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН  
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ



НИДЕРЛАНДЫН ВАНТ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

